“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2025 оны 01 сарын 08 өдөр Дугаар 01 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Компанийн 2025 оны бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг дэмжих тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”, Эрчим хүчний сайдын 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/16 дугаар тушаал, 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн а/58 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийн дагуу компанийн 2025 оны бараа, ажил үйлчилгээг худалдан авах төлөвлөгөөг хэлэлцэв.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

1.Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хэлэлцэн дэмжив;

2.”Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хууль тогтоомжид заасан хугацаанд холбогдох газарт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд даалгав;

3.Компанийн 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Шилэн дансны цахим системд хуулийн хугацаанд байршуулах, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хагас бүтэн жилээр Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд үүрэг болгов” гэжээ.

ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ХК-ИЙН ДОРНОД БҮСИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374 262*651
ДОРНОД АЙМАГ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

## ДБЭХС ТӨХК-ИЙН 2025 ОНД БАРАА, АЖИЛ , ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

25.01.07 Хэрлэн сум

| д/д | Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний санхүүжилтийн эх үүсвэр, нэр, төрөл, тоо хэмжээ, хүчин чадал | Төрөл (бараа, ажил, зөвлөх үйлчилгээ,зөвлөх өөс бусад үйлчилгээ | Батлагдсан төсөвт өртөг (мян.төг) | Тухайн онд санхүүжих дүн (мян.төг) | Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам | Тендер зарлах огноо | тогтвортой худалдан авах ажиллагааны шалгуур тавих эсэх | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| АЛТААР ХИЙГДЭХ АЖИЛ | | | | | | | | |
| 1 | "Чойбалсан-Баруун Урт" 110кВ-ын ЦДАШ-ын засварын материал | бараа | 550,000.00 | 550,000.00 | НТШ | 2025.03.18 | | |
| 2 | Цахилгаан шугам сүлжээний засварын материал | бараа | 280,000.00 | 280,000.00 | НТШ | 2025.02.03 | | |
| 3 | ЦРП-1,5 дэд станцуудын вакуум таслуур | бараа | 260,000.00 | 260,000.00 | НТШ | 2025.02.04 | | |
| 4 | Дулааны хянах хэмжих хэрэгсэл | бараа | 180,272.00 | 180,272.00 | НТШ | 2025.03.17 | | |
| 5 | Дэд станцын хүчний кабель | бараа | 140,000.00 | 140,000.00 | НТШ | 2025.03.19 | | |
| 6 | Шуурхай ажиллагааны автомашин | бараа | 140,000.00 | 140,000.00 | НТШ | 2025.03.26 | | |
| 7 | Зуухны тээрмийн алх баригч, нүүрс тэжээгчийн гинж | бараа | 104,000.00 | 104,000.00 | НТШ | 2025.02.10 | | |
| 8 | Компьютер техник хэрэгсэл | бараа | 102,256.00 | 102,256.00 | НТШ | 2025.01.30 | | |
| 9 | Хүчний трансформатор 35/10кВ | бараа | 95,000.00 | 95,000.00 | ХА | 2025.02.07 | | |
| 10 | Экскаватор | бараа | 90,000.00 | 90,000.00 | ХА | 2025.01.22 | | |
| 11 | Металын лабораторийн тоног төхөөрөмж | бараа | 81,000.00 | 81,000.00 | ХА | 2025.02.06 | | |
| 12 | Турбогенератор №1,2 ын удирдлагын системийн программ хангамж | бараа | 79,580.00 | 79,580.00 | ХА | 2025.02.06 | | |
| 13 | Цахилгаан тоноглолын засварын материал | бараа | 79,500.00 | 79,500.00 | ХА | 2025.01.28 | | |
| 14 | Элегаз таслуур 110кВ | бараа | 70,000.00 | 70,000.00 | ХА | 2025.02.11 | | |
| 15 | Масло цэвэрлэх центрфуг | бараа | 60,000.00 | 60,000.00 | ХА | 2025.03.12 | | |
| 16 | Зуухны тэжээлийн усны пультны гурвалсан хаалт | бараа | 55,000.00 | 55,000.00 | ХА | 2025.03.05 | | |
| 17 | Авто ачигч /Ковш/ | бараа | 50,000.00 | 50,000.00 | ХА | 2025.01.20 | | |
| 18 | Цаг бүртгэлийн систем | бараа | 45,000.00 | 45,000.00 | НЭҮ | 2025.02.11 | | |
| 19 | Вакуум таслуур | бараа | 40,000.00 | 40,000.00 | ХА | 2025.02.17 | | |
| 20 | Төмөр бетон тулгуур | бараа | 39,900.00 | 39,900.00 | ХА | 2025.02.25 | | |
| 21 | Түлшний бутлагчийн алх | бараа | 30,000.00 | 30,000.00 | ХА | 2025.03.10 | | |
| 22 | Химийн лабораторийн тоног төхөөрөмж | бараа | 21,758.00 | 21,758.00 | ХА | 2025.01.27 | | |
| 23 | Богино долгионы станц | бараа | 19,600.00 | 19,600.00 | ШХА | | | |
| 24 | Шинэ конторт хэрэглээний халуун усны шугамд хэрэглэх материал | бараа | 18,000.00 | 18,000.00 | ШХА | | | |
| 25 | Дэд станцын дээврийн засварын материал | бараа | 10,112.00 | 10,112.00 | ШХА | | | |
| 26 | Хүчний трансформатор 15/0.4кВ, 10/0.4кВ | бараа | 20,000.00 | 20,000.00 | ШХА | | | |
| 27 | Архивын шүүгээ | бараа | 6,000.00 | 6,000.00 | ШХА | | | |
| | **ДҮН** | | **2,666,978.00** | **2,666,978.00** | | | | |
| **( ЗАСВАР** | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 28 | Зуух №5 уур халаагчийн 1, 2 дугаар үе солих | ажил | 743,230.00 | 743,230.00 | НТШ | 2025.01.30 | | |
| 29 | Хуучин хэсгийн хурц уурын шугам солих | ажил | 650,000.00 | 650,000.00 | НТШ | 2025.02.21 | | |
| 30 | Турбогенератор №1 | ажил | 453,962.00 | 453,962.00 | НТШ | 2025.01.31 | | |
| 31 | Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн B1 давхарын барилгын засвар | ажил | 160,000.00 | 160,000.00 | НТШ | 2025.03.04 | | |
| 32 | Конвейер №4 ремень солих | ажил | 78,000.00 | 78,000.00 | ХА | 2025.02.24 | | |
| | **ДҮН** | | **2,085,192.00** | **2,085,192.00** | | | | |
| **В.ТЗБАХ-ЭЭР ХИЙГДЭХ АЖЛУУД** | | | | | | | | |
| 33 | Шинэ конторын барилгын интерьер дизайны зураг гаргах | ажил | 65,000.00 | 65,000.00 | ХА | 2025.02.17 | | |
| 34 | Хяналтын камерын систем суурилуулах | ажил | 51,928.00 | 51,928.00 | ХА | 2025.03.26 | | |
| 35 | 50 МВт станцын ТЭЗҮ-ийн өгөгдөл боловсруулах тооцоололд зөвлөх үйлчилгээ авах | ажил | 19,500.00 | 19,500.00 | ШХА | | | |
| 36 | Галын дохиолол суурилуулах | ажил | 17,064.00 | 17,064.00 | ШХА | | | |
| 37 | 50МВт станцын контор 36МВт-ын үйлдвэр хоёрын хооронд хийгдэх хүзүүвчний зураг төсөв | ажил | 15,285.00 | 15,285.00 | ШХА | | | |
| | **ДҮН** | | **168,777.00** | **168,777.00** | | | | |
| **ҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ** | | | | | | | | |
| 38 | Хөдөлмөр хамгааллын хувцас | Бараа | 216,575 | 216,575 | НТШ | 2025.02.13 | | |
| 39 | Хөдөлмөр хамгааллын гутал | Бараа | 186,100 | 186,100 | НТШ | 2025.02.14 | | |
| 40 | Хөдөлмөр хамгааллын хамгаалах хэрэгсэл | Бараа | 181,068 | 181,068 | НТШ | 2025.02.12 | | |
| 41 | Эрүүл ахуй, цэвэрлэгээний материал | Бараа | 144,284 | 144,284 | НТШ | 2025.02.03 | | |
| 42 | Гэрлийн шил, гэрэлтүүлгийн хэрэгсэл | Бараа | 94,336 | 94,336 | ХА | 2025.02.19 | | |
| 43 | Эмнэлгийн эм, эмийн хэрэгсэл | Бараа | 76,016 | 76,016 | ХА | 2025.02.07 | | |
| 44 | Хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн | Бараа | 37,806 | 37,806 | ХА | 2025.01.24 | | |
| 45 | Галын хор багаж хэрэгсэл | Бараа | 34,652 | 34,652 | ХА | 2025.03.12 | | |
| 46 | Мяндсан шүүр | Бараа | 26,712 | 26,712 | НЭҮ | | | |
| 47 | Хөдөлмөр хамгааллын бээлий | Бараа | 23,565 | 23,565 | ХА | 2025.01.29 | | |
| 48 | Хөвөнтэй бээлий | Бараа | 18,491 | 18,491 | ШХА | | | |
| 49 | хүчилтөрөгчийн коктэйл | Бараа | 14,394 | 14,394 | ШХА | | | |
| 50 | Цэвэрлэгээний шүүр | Бараа | 8,640 | 8,640 | ШХА | | | |
| | **ДҮН** | | **1,062,638.57** | **1,062,638.57** | | | | |
| **ҮДАЛДАН АВАЛТ** | | | | | | | | |
| 51 | Шатахуун, дизель түлш, шатах тослох материал | Бараа | 1,637,880.72 | 1,637,880.72 | НТШ | 2025.02.18 | | |
| 52 | Мазут | Бараа | 870,000.0 | 870,000.0 | НТШ | 2025.02.13 | | |
| 53 | ММТ-1300/1332/735, S16 маркийн алхан тээрмийн алх | Бараа | 364,000.0 | 364,000.0 | НТШ | 2025.02.07 | | |
| 54 | Төмөр | Бараа | 304,830.0 | 304,830.0 | НТШ | 2025.03.20 | | |
| 55 | Бульдозерын сэлбэг | Бараа | 224,666.0 | 224,666.0 | НТШ | 2025.01.31 | | |
| 56 | Химийн бодис | Бараа | 223,786.2 | 223,786.2 | НТШ | 2025.02.10 | | |
| 57 | Барилгын материал | Бараа | 191,391.10 | 191,391.10 | НТШ | 2025.03.13 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 58 | Давс | Бараа | 172,500.0 | 172,500.0 | НТШ | 2025.03.19 | | |
| 59 | Багаж | Бараа | 165,527.0 | 165,527.0 | НТШ | 2025.02.20 | | |
| 60 | Хэмжих хэрэгсэл | Бараа | 154,022.00 | 154,022.00 | НТШ | 2025.03.05 | | |
| 61 | Цахилгааны материал | Бараа | 149,259.7 | 149,259.7 | НТШ | 2025.03.07 | | |
| 62 | Шохойн чулуу | Бараа | 129,000.0 | 129,000.0 | НТШ | 2025.03.18 | | |
| 63 | Өрлөг дулаалгын материал | Бараа | 121,300.0 | 121,300.0 | НТШ | 2025.02.10 | | |
| 64 | Авто машины сэлбэг | Бараа | 114,012.0 | 114,012.0 | НТШ | 2025.02.24 | | |
| 65 | Кабель | Бараа | 75,367.5 | 75,367.5 | ХА | 2025.02.25 | | |
| 66 | Холхивч | Бараа | 69,417.9 | 69,417.9 | ХА | 2025.02.25 | | |
| 67 | Хаалт | Бараа | 59,781.0 | 59,781.0 | ХА | 2025.03.06 | | |
| 68 | Сальник, парнит | Бараа | 57,910.0 | 57,910.0 | ХА | 2025.03.13 | | |
| 69 | Электрод | Бараа | 54,923.3 | 54,923.3 | ХА | 2025.01.30 | | |
| 70 | Компьютерын дагалдах хэрэгсэл | Бараа | 19,894.0 | 19,894.0 | ШХА | | | |
| 71 | Хангамжийн өргөн хэрэглээ | Бараа | 19,066.0 | 19,066.0 | ШХА | | | |
| 72 | Ерөнхий хэрэглээний зардал | Бараа | 17,761.0 | 17,761.0 | ШХА | | | |
| 73 | Төрөл бүрийн хий | Бараа | 15,000.0 | 15,000.0 | ШХА | | | |
| 74 | Бичгийн цаас | Бараа | 13,540.0 | 13,540.0 | ШХА | | | |
| 75 | Бичиг хэргийн дагалдах хэрэгсэл | Бараа | 9,763.6 | 9,763.6 | ШХА | | | |
| 76 | Элс хайрга | Бараа | 5,200.0 | 5,200.0 | ШХА | | | |
| 77 | Принтерийн хор | Бараа | 3,950.0 | 3,950.0 | ШХА | | | |
| 78 | Хэвлэмэл хуудас, журнал | Бараа | 1,648.0 | 1,648.0 | ШХА | | | |
| 79 | Хамар хуяг | Бараа | 13,115.5 | 13,115.5 | ШХА | | | |
| | **ДҮН** | | **5,258,512.5** | **5,258,512.5** | | | | |
| **Е.БУСАД ХУДАЛДАН АВАЛТ** | | | | | | | | |
| 80 | Ажилтнуудын урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ | Ажил | 84,348.0 | 84,348.0 | ХА | 2025.03.07 | | |
| 81 | Даатгалын үйлчилгээ | Зөвлөх бус | 58,349.0 | 58,349.0 | ХА | 2025.03..05 | | |
| 82 | Интернэт үйлчилгээний төлбөр | үйлчилгээ | 46,800.0 | 46,800.0 | НЭҮ | | | |
| 83 | Санхүүгийн тайланд аудит хийх | Зөвлөх | 39,600.0 | 39,600.0 | НЭҮ | | | |
| 84 | Төмөр зам ашиглалтын төлбөр | Ажил | 33,049.6 | 33,049.6 | НЭҮ | | | |
| 85 | Байгаль орчны аудит хийх | Зөвлөх | 25,000.0 | 25,000.0 | НЭҮ | | | |
| 86 | Хэмжих хэрэгсэл баталгаажуулалт-ЦЭХ-ний тоолуур | Ажил | 18,739.5 | 18,739.5 | НЭҮ | | | |
| 87 | Ариутгал халдваргүйжүүлэлт, мэрэгчийн устгал хийлгэх | Ажил | 16,000.0 | 16,000.0 | ШХА | | | |
| 88 | Борлуулалтын программ ашиглалт, үйлчилгээ | Ажил | 12,700.0 | 12,700.0 | ШХА | | | |
| 89 | ЭХҮТ-өөр хийлгүүлэх металл болон лабораторийн шинжилгээний дүгнэлт гаргуулах | үйлчилгээ | 12,400.0 | 12,400.0 | ШХА | | | |
| 90 | Санхүүгийн программ ашиглалт, үйлчилгээ | Ажил | 10,429.7 | 10,429.7 | ШХА | | | |
| 91 | Өргөх зөөх машин механизмуудын магадлагаа хийх | үйлчилгээ | 4,730.0 | 4,730.0 | ШХА | | | |
| 92 | GPS үйлчилгээний төлбөр | Ажил | 4,704.0 | 4,704.0 | ШХА | | | |
| | **ДҮН** | | **366,849.8** | **366,849.8** | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Ё.СҮХБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ САЛБАР** | | | | | | | | |
| 93 | Цахилгааны тоног төхөөрөмж | Бараа | 99,418.0 | 99,418.0 | НТШ | 2025.02.14 | | |
| 94 | Цахилгааны өргөн хэрэглээний материал | Бараа | 86,817.8 | 86,817.8 | НТШ | 2025.02.12 | | |
| 95 | Барилга, сантехникийн материал | Бараа | 68,579.8 | 68,579.8 | ХА | 2025.02.05 | | |
| 96 | Бүх төрлийн цахилгааны кабель болон дамжуулагч утас | Бараа | 57,505.4 | 57,505.4 | ХА | 2025.03.06 | | |
| 97 | Автомашины сэлбэг | Бараа | 49,530.8 | 49,530.8 | ХА | 2025.02.05 | | |
| 98 | ХХ-ын хэрэгсэл | Бараа | 19,992.5 | 19,992.5 | ШХА | | | |
| 99 | Ажлын багаж хэрэгсэл | Бараа | 11,700.0 | 11,700.0 | ШХА | | | |
| 100 | Гэрэл, гэрэлтүүлгийн хэрэгсэл | Бараа | 7,821.0 | 7,821.0 | ШХА | | | |
| 101 | Бичиг хэргийн материал | Бараа | 6,518.9 | 6,518.9 | ШХА | | | |
| 102 | Эрүүл ахуй цэвэрлэгээний материал | Бараа | 5,677.7 | 5,677.7 | ШХА | | | |
| 103 | Принтерийн хор | Бараа | 4,602.0 | 4,602.0 | ШХА | | | |
| 104 | Хэрэглээний төмөр, лист | Бараа | 3,292.9 | 3,292.9 | ШХА | | | |
| | **ДҮН** | | **421,456.8** | **421,456.8** | | | | |
| | **НИЙТ ДҮН** | | **12,030,404.75** | **12,030,404.75** | | | | |

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
# ТОГТООЛ

2025 оны 02 сарын 13 өдөр Дугаар 01 Хэрлэн сум

Компанийн ажилтнуудад 2024 оны
жилийн үйл ажиллагааны үр дүнгээр
олгох нэмэгдлийн тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Эрчим хүчний салбарын хамт /тариф/-ын хэлэлцээрийн 3.6, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.3.17, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын дүгнэлт, Эрчим хүчний сайдын 2025 оны 02 дугээр сарын 10-ны өдрийн а/451 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2024 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний биелэлтийг харгалзан ажилтнуудад 2024 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсний дээд хэмжээг 3 сараар тогтоосугай.

2.Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны үр дүнгээр олгох нэмэгдэл хөлсийг батлагдсан санд багтаан холбогдох журмын дагуу тооцож олгохыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хороо (Б.Мөнхбаатар)-д үүрэг болгосугай.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ДОРНОД БҮСИЙН СИСТЕМ ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 262^651 ДОРНОД АЙМАГ

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 02 сарын 18 өдөр Дугаар 02 Хэрлэн сум

Компанийн бүтэц, зохион байгуулалт,
орон тооны дээд хязгаарыг шинэчлэн
батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.3.4 дэх заалт, Эрчим хүчний сайдын 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн а/516 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн зохион байгуулалтын бүтцийг нэгдүгээр хавсралтаар, ажилтан, албан хаагчдын орон тооны дээд хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Компанийн батлагдсан бүтэц, зохион байгуулалтыг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 31 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ P0374 2622651 ДОРНОД АЙМАГ

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолын
Хавсралт-1

"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн Зохион байгуулалтын бүтцийн схем



"Дорнод бүсийн эрчим хүчний систем" ТӨХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар
сарын 18-ны өдрийн 02 дугаар тогтоолын
Хавсралт-2

"ДБЭХС" ТӨХК-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨӨРЧЛӨЛТӨӨР
НЭГЖ ХЭСГҮҮДЭД АЖИЛЛАХ АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН ТОО

| д/д | Компанийн нэгж, хэсгийн нэр | Орон тоо | | | Бүгд |
|---|---|---|---|---|---|
| | | Удирдлага | ИТА | Ажилтан | |
| 1 | Удирдлага | 1 | | | 1 |
| 2 | Ерөнхий инженер | 1 | | | 1 |
| 3 | Дотоод аудитор | 1 | | | 1 |
| 4 | Хяналт хариуцсан менежер | 1 | | | 1 |
| 5 | Маркетинг, ил тод байдал хариуцсан менежер | 1 | | | 1 |
| 6 | Төслийн зохицуулагч | | 1 | | 1 |
| 7 | Захиргаа, хүний нөөцийн хэлтэс | 1 | 6 | | 7 |
| 8 | Санхүү, эдийн засгийн хэлтэс | 1 | 12 | | 13 |
| 9 | Худалдан авах ажиллагааны хэлтэс | 1 | 5 | | 6 |
| 10 | Хяналт, аюулгүй ажиллагааны хэлтэс | 1 | 10 | | 11 |
| 11 | Нийтлэг үйлчилгээний хэлтэс | 1 | 7 | | 8 |
| 12 | Үйлдвэрлэл, шуурхай ажиллагааны алба | 1 | 14 | | 15 |
| 13 | Техникийн бодлогын хэлтэс | 1 | 6 | | 7 |
| 14 | Эрчим хүч борлуулалтын хэлтэс | 1 | 16 | 38 | 55 |
| 15 | Сүхбаатар ЦТС салбар | 1 | 18 | 67 | 86 |
| 16 | Түлш дамжуулах цех | 1 | 8 | 63 | 72 |
| 17 | Зуухан цех | 1 | 12 | 101 | 114 |
| 18 | Турбин цех | 1 | 12 | 61 | 74 |
| 19 | Хими цех | 1 | 7 | 28 | 36 |
| 20 | Цахилгаан цех | 1 | 12 | 38 | 51 |
| 21 | К-ДХА цех | 1 | 11 | 19 | 31 |
| 22 | Цахилгаан шугам сүлжээний цех | 1 | 6 | 66 | 73 |
| 23 | Дулааны шугам сүлжээний цех | 1 | 1 | 15 | 17 |
| 24 | Бэлтгэх хэсэг | | | 15 | 15 |
| 25 | Үйлчилгээний ажилтнууд | | | 18 | 18 |
| 26 | Автограж | | | 25 | 25 |
| | **БҮГД** | **22** | **164** | **554** | **740** |

**“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”**
**ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН**
**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН**
**ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС**

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар 03 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын гүйцэтгэлийг танилцуулах тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 05 дугаар тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсвийг 169,355.0 мянган төгрөгөөр баталсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал 2024 оны гүйцэтгэлээр 155,167.0 мянган төгрөг гарч 14,188.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“...Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны зардлын гүйцэтгэлийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга нарт тус тус даалгав...” гэжээ.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар 03 Хэрлэн сум

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны
хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 80 дугаар зүйлийн 80.1, 80.2 дахь хэсэг, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн дүрмийн 7.9 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн а/699 дугаар албан бичгээр ирүүлсэн удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2.Төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд, хурлаар хэлэлцэх асуудлыг бэлтгэн тогтоосон хугацаанд хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайханд, хурлыг тухай бүр журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Т.Болортуяад тус тус даалгасугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт

# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2025 ОНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/Д | Хугацаа | ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал | Хариуцах албан тушаалтан |
|---|---|---|---|
| 1 | 1 сар | 2025 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөний тухай | ХуААХ-ийн дарга |
| 2 | 3 сар | ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудиторын 2024 оны ажлын тайланг танилцуулах тухай | Дотоод аудитор |
| 3 | | ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудиторын 2025 оны ажлын төлөвлөгөөг батлах тухай | Дотоод аудитор |
| 4 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайланг танилцуулах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 5 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 6 | | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны зардлын төлөвлөгөөг дэмжих тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 7 | | Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн тухай | СЭЗХ-ийн дарга |
| 8 | | Хувьцаа эзэмшигчдийн хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг батлах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 9 | | Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үүрэг, зорилтот түвшингийн биелэлтийг хэлэлцэн, үнэлэлт дүгнэлт өгөх тухай | Гүйцэтгэх захирал |
| 10 | | Ногдол ашгийн тухай | Гүйцэтгэх захирал |
| 11 | 4 сар | 2024 оны худалдан авах ажиллагаанд хийсэн Дотоод аудиторын тайлан дүгнэлт | Дотоод аудитор |
| 12 | | Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөө батлах тухай | Гүйцэтгэх захирал |
| 13 | | Компанийн 2024-2025 оны өвлийн их ачааллыг давсан тухай тайлан | Ерөнхий инженер |
| 14 | 5 сар | Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах тухай | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 15 | 7 сар | Компанийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан тэнцэл, техник эдийн засгийн үзүүлэлтийн гүйцэтгэлийн тухай | СЭЗХ-ийн дарга |
| 16 | | Компанийн 2025 оны худалдан авах төлөвлөгөөний хагас жилийн биелэлтийн тухай | ХуААХ-ийн дарга |
| 17 | 8 сар | Компанийн 2025 оны зорилтот түвшинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | СЭЗХ-ийн дарга |
| 18 | 9 сар | Компанийн үндсэн хөрөнгө, хөрөнгийн ашиглалт, түүнтэй холбоотой авах арга хэмжээний тухай | СЭЗХ-ийн дарга |

| | | | |
|---|---|---|---|
| 19 | | Компанийн 2025-2026 оны өвлийн бэлтгэл ажлын явцын тухай | Ерөнхий инженер |
| 20 | 10 сар | 2025 оны их болон урсгал засварын ажил, ТЗБАХ, хөрөнгө оруулалтын ажлын явцын тухай | Ерөнхий инженер |
| 21 | | Компанийн 2025-2026 оны өвлийн бэлтгэл ажил хэрхэн хангагдсан тухай | Ерөнхий инженер |
| 22 | 12 сар | Компанийн 2026 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, их засвар, ТЗБАХ-ийн төлөвлөгөөний тухай | Гүйцэтгэх захирал |
| 23 | Жилд 1 удаа | Компанийн үйл ажиллагаатай очиж танилцах | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 24 | Тухай бүр | Цаг үеийн шаардлагатай асуудлыг тухайн үед нь хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд нэмж оруулан, хэлэлцэн шийдвэрлэх | Холбогдох албан тушаалтан |
| 25 | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 81.4-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах | Аудитын хороо |
| 26 | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 81.5-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах | Нэр дэвшүүлэх хороо |
| 27 | Тухай бүр | Компанийн тухай хуулийн 81.6-д заасан чиглэлээр дүгнэлт зөвлөмж гарган Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулах | Цалин урамшууллын хороо |

---oOo---

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар 04 Хэрлэн сум

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ
ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 71 дүгээр зүйлийн 71.3, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.3 дахь хэсэг, Эрчим хүчний сайдын 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн а/823 тоот удирдамжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 16:00 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг гуравдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг дөрөвдүгээр хавсралтаар, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт бэлэн болгох хугацааг тавдугаар хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг зургаадугаар хавсралтаар тус тус батлсугай.

3.Хурлын тооллогын комиссыг доорх бүрэлдэхүүнтэйгээр батлсугай. Үүнд:

Тооллогын комиссын дарга:
Т.Оюун- Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга
Гишүүд:
Э.Энхцэцэг-Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн
Б.Маналжав-Архив, бичиг хэргийн ажилтан

4.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Тавинбэхийг сонгосугай.

5.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах өдрийг 2025 оны 03 дугаар сарын 23-ны өдрөөр, хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн өдрийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ны өдрөөр тус тус тогтоосугай.

6.Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, холбогдох материалуудыг Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА О.ХУЯГЦОГТ

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ..... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ДОРНОД ТТР0374 262 651 ДОРНОД АЙМАГ

КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай;

2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай;

4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай;

6. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;

7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай;

8. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;

_____oOo______

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
хоёдугаар хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
ТТР0374 262 651
ДОРНОД АЙМАГ

# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ” ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛД САНАЛ АВАХ ХУУДАС

“ Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 16:00 цагт “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд боллоо.

| | | |
|---|---|---|
| Хувьцаа эзэмшигчийн овог нэр: | ЭХЯ, | ТӨБЗГ |
| Хувьцаа эзэмшигчийн утасны дугаар | 62263051, | 51-262350, |
| Хувьцаа эзэмшигчийн мэйл хаяг | info@energy.gov.mn , | info@pcsp.gov.mn |
| Регистрийн дугаар | 5638089, | 6098169 |
| Эзэмшиж буй хувьцааны тоо | Эрчим хүчний яам 66%<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар 34% | |

Санал хураах арга: Энгийн

| № | Санал авах асуудлууд | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|---|---|---|---|---|
| 1 | Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 2 | Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 3 | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 4 | Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 5 | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай | ☐ | ☐ | ☐ |
| 6 | Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах болон компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 7 | Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай | ☐ | ☐ | ☐ |
| 8 | Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал | ☐ | ☐ | ☐ |

Заавар: Та өөрийн саналыг + тэмдгээр бичнэ үү.

| |
|---|
| Хувьцаа эзэмшигчийг төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн төлөөлөгчийн<br><br>Нэр....................................................<br>Албан тушаал..................................<br>Гарын үсэг...................................... |
| Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо. цаг ........................................................ |
| Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг ............................/ / |

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх (доогуур зурах): Тийм Үгүй

Тооллогын комиссын дарга: Т.Оюун / Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга /

Гишүүд: Э.Энхцэцэг / Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн/
Б.Маналжав / Архив, бичиг хэргийн ажилтан/

Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл:

..................................................................................................................................................................

..................................................................................................................................................................

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
гуравдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр: | “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК |
| Хаяг: | Дорнод аймаг, Хэрлэн сум, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн байр |
| Хурал хуралдах өдөр, цаг: | 2025.04.29-ний өдөр 16:00 цаг |
| Хурал хуралдах газар /хаяг, байршил/: | Эрчим хүчний яам /Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Засгийн газрын XIV байр / |
| Хурлын төрөл: | Ээлжит |
| Хурал зарлагч: | Төлөөлөн удирдах зөвлөл |
| Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо: | 2025.03.18 |
| Олон нийтэд зарлах огноо: | 2025.03.24 |
| Бүртгэлийн өдөр: | 2025.04.10 |
| Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо: | 2025.03.21 |
| Хүргүүлсэн огноо: | 2025.03.21 |
| Хурлын даргын нэр: | Хувьцаа эзэмшигчдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Тавинбэх |
| Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр: | Комиссын дарга: Т.Оюун , Гишүүд: Э.Энхцэцэг, Б.Маналжав |
| Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/: | - Хурал хуралдуулах тухай шийдвэр<br>- Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлэх зарын загвар<br>- Саналын хуудасны загварууд<br>- Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа |
| Баримт бичгийн хуудасны тоо: | ........... хуудас |

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

.......... оны ......... дүгээр сарын ........ –ны өдөр

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
дөрөвдүгээр хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 262^651 ДОРНОД АЙМАГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар

**Компанийн оноосон нэр:** “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК

**Хаяг:** Дорнод аймаг, Хэрлэн сум, “Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн байр

**Хурал хуралдуулах газар, өдөр, цаг:** “Эрчим хүчний яам”-ны хурлын танхимд 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 16:00 цагт

**Бүртгэлийн өдөр:** 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай;
2. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай;
4. Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах тухай;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай;
6. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
7. Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай;

**Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдөр, журам:**

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй 2025 оны 04 дүгээр сарын 04-ны өдрөөс эхлэн 09:30- 17:30 цагийн хооронд 88094897 утсаар болон Эрчим хүчний яамны байранд ирж Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Т.Болортуяагаас цахим хэлбэрээр авч танилцаж болно.

**Хуралд бэлтгэх явцад хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах шийдвэр
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх “Саналын хуудас”
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалууд
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл
5. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
тавдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБОГДСОН МЭДЭЭЛИЙН ЖАГСААЛТ БЭЛЭН БОЛГОХ ЭЦСИЙН ХУГАЦАА

| № | Хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл | Бэлэн болох хугацаа |
|---|---|---|
| 1 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол | 2025.03.18 |
| 2 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл | 2025.03.21 |
| 3 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар | 2025.03.24 |
| 4 | Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын саналын хуудас | 2025.04.24 |
| 5 | Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай | 2025.03.31 |
| 6 | Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай | 2025.03.31 |
| 7 | Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны зардлын төсөв батлах тухай | 2025.03.31 |
| 8 | Ногдол ашиг хуваарилах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах. | 2025.03.31 |
| 9 | Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай | 2025.03.31 |
| 11 | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай | 2025.03.31 |

_____oOo______

“Дорнод бүсийн эрчим хүчний систем”
ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2025 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тогтоолын
зургаадугаар хавсралт

# “ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ”ТӨХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 29-ны өдрийн 16:00 цагт Эрчим хүчний яамны хурлын танхимд болно.

| Д/д | Хэлэлцэх асуудлын дараалал | Гарах шийдвэр | Хугацаа | Хариуцах эзэн |
|---|---|---|---|---|
| 1 | Бүртгэлийн үйл ажиллагаа<br>Хурлын ирцийг бүртгэх, мэдээлэх | - | 16:00-16:05 | Тооллогын комисс |
| 2 | Хурлын нээлт<br>-Хурлыг нээх, хурлын дэг танилцуулах | - | 16:05-16:10 | Хурлын дарга |
| 3 | Хэлэлцэх асуудал-1<br>Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 16:10-16:15 | Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан<br>Ерөнхий нягтлан бодогч Б.Энхбаатар |
| 4 | Хэлэлцэх асуудал-2<br>Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 16:15-16:20 | ТУЗ-ийн дарга О.Хуягцогт |
| 5 | Хэлэлцэх асуудал-3<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайлан, 2025 оны зардлын төсвийн төсөв батлах тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 16:20-16:25 | ТУЗ-ийн дарга О.Хуягцогт |
| 6 | Хэлэлцэх асуудал-4<br>Ногдол ашгийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 16:25-16:30 | Ерөнхий нягтлан бодогч Б.Энхбаатар |
| 7 | Хэлэлцэх асуудал-5<br>Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг чөлөөлж, сонгох тухай<br>-Асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 16:30-16:35 | Нэр дэвшүүлэх түр хорооны дарга |
| 8 | Хэлэлцэх асуудал-6<br>Компанийн гүйцэтгэх захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг танилцуулах тухай<br>-асуулт /1хүн 2 минут/, хариулт | Тогтоол | 16:35-16:40 | Гүйцэтгэх захирал Ө.Жаргалсайхан |
| 9 | Хэлэлцэх асуудал-7<br>Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай | Тогтоол | 16:40-16:45 | ТУЗ-ийн дарга О.Хуягцогт |
| 10 | Санал хураалт | - | 16:45-16:50 | Тооллогын комисс |
| 11 | Хурал хаах | - | 16:50-16:25 | Хурлын дарга |

_____oOo______

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар 05 Хэрлэн сум

Нэр дэвшүүлэх түр хороо
байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх заалт, Эрчим хүчний салбарын төрийн өмчит хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.”Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах үүрэг бүхий Нэр дэвшүүлэх түр хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Нэр дэвшүүлэх түр хорооны дарга: Д.Оюунчимэг
Гишүүн: Б.Энхтөр
Гишүүн: В.Дарханбаатар

2.Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, сонгон шалгаруулалтын тайлан, дүгнэлт, нэр дэвшигчийг үнэлгээний жагсаалтын хамт Хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулан шийдвэрлүүлэхийг Нэр дэвшүүлэх түр хорооны дарга (Д.Оюунчимэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА О.ХУЯГЦОГТ

ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ ТТР0374 ш. 2620651 ДОРНОД АЙМАГ

“ДОРНОД БҮСИЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ”
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭС

2025 оны 03 сарын 18 өдөр Дугаар 02 Хэрлэн сум

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын тэмдэглэлд:

**ХЭЛЭЛЦСЭН нь:**

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай

**ТЭМДЭГЛЭСЭН нь:**

“Дорнод бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2024 онд нийт 18 удаа хуралдан 53 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, 31 тогтоол, 22 тэмдэглэлээр холбогдох албан тушаалтнуудад үүрэг даалгавар өгсөн байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны шийдвэрийн биелэлт 97.0% байна.

**ШИЙДВЭРЛЭСЭН нь:**

“...Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны ажлын тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон нарийн бичгийн дарга нарт тус тус даалгав...” гэжээ.

ДАРГА О.ХУЯГЦОГТ